| **Аудит хийгдэх нэгж:** | **Огноо:** |
|---|---|
| Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,Сүрьеэгийн төсөл , Коронавируст халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан 2020-2021 онд Монгол Улсад олгосон буцалтгүй тусламж, Вируст гепатитаас сэргийлэх төсөл | 2022 оны 5 дугаар сар |

**Дотоод аудитын нэгж:**

ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

# -ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН-

## Аудитын нэр: Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2021 оны үйл ажиллагаа, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан 2020-2021 онд Монгол Улсад олгосон буцалтгүй тусламж, Вируст гепатитаас сэргийлэх төслийн санхүүгийн хяналт-шалгалт

**2022.05 дугаар сар**

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:** Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл хэрэгжүүлэгч нэгж

**АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ:** Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,Сүрьеэгийн төсөл, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан 2020-2021 онд Монгол Улсад олгосон буцалтгүй тусламж, Вирусt гепатитаас сэргийлэх төсөл

**АУДИТЫН ТӨРӨЛ:** Гүйцэтгэлийн аудит

**АУДИТЫН ХУГАЦАА:** 2022 оны 5 дугаар сар

**Дотоод аудитын нэгжийн дарга:** С.Төгсдэлгэр

**Аудитыг гүйцэтгэсэн:** Х.Өлзий-Орших

Г.Туул

Д.Тунгалаг

## АГУУЛГА


- **ТАНИЛЦУУЛГА**
  - **Аудитын зорилго**
  - **Цар хүрээ**
- **ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА**
- **АУДИТЫН ҮР ДҮН**
  - **Өмнөх шалгалтын талаар**
  - **Аудитаар илэрсэн зөрчил**
- **ДҮГНЭЛТ**
- **ЗӨВЛӨМЖ**

# 1. ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Ерөнхий зүйл

Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамжийн дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2021 оны үйл ажиллагаа, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан 2020-2021 онд Монгол Улсад олгосон буцалтгүй тусламж, Вируст гепатитаас сэргийлэх төслийн санхүүгийн хяналт, шалгалтын ажлыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Салбарын санхүүгийн хяналт шалгалт, гүйцэтгэлийн санхүүжилтийн дотоод аудит хариуцсан шинжээч Х.Өлзий-Орших, Салбарын санхүүгийн хяналт шалгалт, аудит хариуцсан шинжээч Г.Туул, Төсөл, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч Д.Тунгалаг нар хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг гүйцэтгэхдээ дараах хууль, тогтоомж болон бусад баримт бичгийг ашигласан. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Улсын салбарын Дотоод аудитын гарын авлага
- Дотоод аудитын Мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”

Шалгалтыг хийж гүйцэтгэхдээ анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтын хөтлөлтийг шалгах, санхүүгийн тайлан тэнцлийн үзүүлэлттэй уялдуулан түүвэрчлэн шалгах, асууж тодруулах, засвар үйлчилгээ авсан гэх объектыг биечлэн шалгах зэрэг аргыг ашигласан. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2021 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт хийх удирдамжтай байсан болович Хөтөлбөр зохицуулах нэгжээс ирүүлсэн мэдээллийн дагуу 2020 оны санхүүгийн баримтыг хэсэгчлэн шалгасан.

## 1.2 Аудитын зорилго

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2021 оны үйл ажиллагаа, коронавируст халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан 2020-2021 онд Монгол Улсад олгосон буцалтгүй тусламж, вируст гепатитаас сэргийлэх төслийн санхүүгийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэн, тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, засч сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөхөд оршино.

## 1.3 Цар хүрээ

Монгол Улсын эрүүл мэндийн салбарт Глобаль сангийн дэмжлэгтэйгээр хэрэгждэг 3 төслийн 2020-2021 оны үйл ажиллагааны санхүүгийн хяналт, шалгалт.

## 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2.1 ДОХ, сүрьеэгийн төсөл

Глобаль сан нь ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх төслүүдийг шалгаруулж, дэлхийн улс орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг бөгөөд төсөл хэрэгжүүлэх улсад Үндэсний зохицуулах зөвлөл, Хөтөлбөр зохицуулах нэгж, Сангийн орон нутгийн агент, Салбар хүлээн авагч байгууллагуудтай хамтран ажилладаг. Монгол Улсын эрүүл мэндийн салбарт 2003 оноос эхлэн дэмжлэг үзүүлж, 2003-2020 онд нийт 24.0 сая ам.долларын санхүүжилттэй ДОХ-ын 6 төсөл, нийт 38.4 сая ам.долларын санхүүжилттэй сүрьеэгийн 6 төсөл, Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх 5.3 сая ам.долларын 3 төслийг хэрэгжүүлжээ.

Монгол Улсад ХДХВ/ДОХ, сүрьеэгээс сэргийлэх, эмчилгээ тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх төслийг боловсруулж, 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Глобаль сангийн удирдах зөвлөлөөр батлуулан, 2021-2023 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төслийн нийт санхүүжилт 13.34 сая ам доллар бөгөөд үүний 10.72 сая ам долларыг сүрьеэгийн төсөлд, 2.63 сая ам долларыг ДОХ-ын төсөлд зарцуулна. Нийт санхүүжилтийн 40.8 хувь буюу 5.45 сая амдолларыг 2021 онд зарцуулахаар баталсан байна.

ДОХ, Сүрьеэгийн төслийн нийт зардлын төрлийг хувиар илэрхийлэн Зураг 1-т үзүүлэв.

Зураг 1. ДОХ, сүрьеэгийн төслийн зардлын төрөл, хувиар /2021-2023 он/




Сүрьеэгийн төслийн санхүүжилтийг салбар хүлээн авагч буюу хэрэгжүүлэгч байгууллагаар авч үзвэл нийт санхүүжилтийн 69 хувийг ХӨСҮТ-д 19 хувийг Төрийн бус байгууллагуудад, 12 хувийг Хөтөлбөр зохицуулах нэгжид зарцуулдаг байна.

ДОХ-ын төслийн хувьд нийт санхүүжилтийн 54 хувийг Төрийн бус байгууллагуудад, 31 хувийг ХӨСҮТ-д, 15 хувийг Хөтөлбөр зохицуулах нэгжид зарцуулдаг.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу төслийн салбар хүлээн авагч 10 байгууллагад 2021 онд 9.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласан байна.

Төслөөс 2021 онд нийт 2.0 сая ам долларын ханган нийлүүлэлтийн захиалга хийгдсэнээс 325.13 мянган ам долларын сүрьеэгийн эм, 678.0 мянган ам долларын урвалж бодис, лабораторийн хэрэгсэл, 729.0 мянган ам долларын эмнэлгийн тоног төхөөрөмж, 257.0 мянган ам долларын автомашин, 85.5 мянган ам долларын БЗДХ-ын эм оношлуурын захиалга тус тус байна. Нийт 1.8 сая ам долларын эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж оношлуурын ханган нийлүүлэлтийг 2021 онд хийжээ.

## 2.2 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан 2020-2021 онд Монгол Улсад олгосон буцалтгүй тусламж

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөллийг бууруулах нэмэлт санхүүжилтийн төсөл боловсруулан, Глобаль санд хүргүүлж, батлуулсан байна. Төслийн нийт санхүүжилт 4.1 сая ам доллар бөгөөд үүний 82.3 хувь буюу 3.4 сая ам. долларыг 2021 онд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн төслөөс 2021 онд 2.4 сая ам долларын эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэнээс 409.61 мянган ам долларын КОВИД-19-ийн оношлуур, 355.5 мянган ам долларын тарилга, 953.3 мянган ам долларын урвалж, 207.43 мянган ам долларын хувийн хамгаалах хэрэгсэл, 260.16 мянган ам долларын эмнэлгийн хэрэгсэл,176.06 мянган ам долларын амьсгалын аппаратын захиалга тус тус байна. Захиалгаас КОВИД-19-ийн оношлуур, тарилга, урвалж бодис, амьсгалын аппаратын ханган нийлүүлэлт 100 хувь хийгджээ.

## 2.3 Азийн хөгжлийн банк, Глобаль сангийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжсэн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх замаар вирусt гепатит, сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааг сайжруулах төсөл

Вируст гепатитын урьдчилан сэргийлэлт, илрүүлгийг сайжруулах Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны төсөл 2018 оны 6 дугаар сараас, Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлгийг сайжруулах бүрэлдэхүүн хэсэг Глобаль сангийн санхүүжилтээр 2019 оны 10 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд хамтарсан төслийн үндсэн үйл ажиллагаа 2020 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон. Төслийн нийт санхүүжилт 1.3 сая ам доллар бөгөөд үүнээс 800.0 мянган ам долларыг Азийн хөгжлийн банк, 500.0 мянган долларыг Глобаль сангаас тус тус санхүүжүүлсэн байна. Глобаль сангийн санхүүжилтийн 67.8 хувийг мэдээлэл, сургалт сурталчилгаанд, 17.9 хувийг сургалтад, 12.9 хувийг зөвлөхүүдийн цалинд, 1.4 хувийг захиргааны зардалд тус тус зарцуулсан байна.

# 3. АУДИТЫН ҮР ДҮН

## 3.1 Өмнөх шалгалтын талаар

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд ҮАГ-аас аудит хийж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан тул “Зөрчилгүй” дүгнэлтийг өгсөн байна.

Аудитаар нийт 86.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 32.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

## 3.2 Аудитаар илэрсэн зөрчил

**Нэг. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,сүрьеэгийн төслийн 2021 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт хийх удирдамжтай байсан боловч Хөтөлбөр зохицуулах нэгжээс ирүүлсэн мэдээллийн дагуу 2020 оны санхүүгийн баримтыг хэсэгчлэн шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:**

1. Мэдээлэл, сургалт сурталчилгааны материал боловсруулах, хэвлүүлэх, программ хангамжийн холболт хийх ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах улсын бүртгэлийн гэрчилгээгүй байгууллагаар гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

   - КОВИД-19 цар тахлын үед сүрьеэтэй өвчтөнүүдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх сургалтын материал бэлтгэх ажлын удирдамжийг 2020 оны 10 дугаар сард Эрүүл мэндийн сайдаар, төсвийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан, хэрэгжүүлсэн байна. Ажлын нийт төсөв 31.0 сая төгрөг бөгөөд худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглаж, Ажил гүйцэтгэх гэрээг ЭМЯ-ны ТНБД Я.А[redacted] батлуулан, “Баян-Өлгий капитал” ХХК-тай байгуулжээ. Энэхүү компани нь Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд “Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа” чиглэлээр үйл ажиллагаа явуулах улсын бүртгэлийн гэрчилгээтэй байгууллага байна. ЭМЯ-ны ХШҮДАГ-аас 2021 оны 10 дугаар сард Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төсөлд хийсэн дотоод аудитын тайланд энэ талаар мөн дурьдсан байна. Хөтөлбөр зохицуулах нэгжээс ирүүлсэн мэдээллийн дагуу дахин шалгахад “Баян-Өлгий капитал” ХХК-ний баримтад хавсаргасан улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг засварлаж, санхүүгийн анхан шатны баримтад шинээр хавсаргасан зөрчил илэрлээ. Тухайлбал: “Баян-Өлгий капитал” ХХК-ний 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр авсан улсын бүртгэлийн гэрчилгээн дэх эрхлэх үйл ажиллагааны чиглэл нь “Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа” гэсэн байсныг “Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх график дизайн” болгон өөрчилсөн байна. Гэрчилгээг засварлахдаа үйл ажиллагааны чиглэлийн код /4610 буюу худалдаа, үйлчилгээ эрх үйл ажиллагааны код/-ыг хэвээр үлдээжээ. График дизайны үйл ажиллагаа эрхлэх чиглэлийн улсын бүртгэлийн код нь

4330 байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим санд "Баян-Өлгий капитал" ХХК нь "Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа" чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хэвээр, үйл ажиллагааны чиглэлд нэмэлт ороогүй болохыг харж болно ( opendata.burtgel.gov.mn/lesinfo/3075567).

- КОВИД-19 цар тахлын үед сүрьеэ өвчнөөс сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны материалын эх бэлтгэх, хэвлэх, видео шторк бэлтгэх, цахим мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх 48.41 сая төгрөгийн нийт төсөвтэй ажлын удирдамжийг 2020 оны 9 дүгээр сард Эрүүл мэндийн сайдаар, төсвийг ЭМЯ-ны ТНБД-аар батлуулжээ. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглаж, Ажил гүйцэтгэх гэрээг ЭМЯ-ны ТНБД Я.А[redacted] батлуулан, "Ниэр Фийлд Коммуникейшн" ХХК-тай байгуулсан байна. Санхүүгийн анхан шатны баримтад "Ниэр Фийлд Коммуникейшн" ХХК-ний Улсын бүртгэлийн гэрчилгээг хавсаргаагүй байсан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим сангаас мэдээллийг харахад "Программ хангамжийн үйл ажиллагаа, гадаад худалдаа, худалдааны зуучлал, холбооны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ" чиглэлээр үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байв.

- ДОХ, ХДХВ-ийн цахим бүртгэл, мэдээллийн программыг цахим хуудастай холбох 10.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын удирдамжийг Эрүүл мэндийн дэд сайдаар, төсвийг ЭМЯ-ны ТНБД-аар 2020 оны 5 дугаар сард батлуулжээ. Ажил гүйцэтгэх гэрээг ЭМЯ-ны ТНБД Я.А[redacted] батлуулан, "Лүсүн Од" ХХК-тай 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан байна. Энэхүү компани нь "Гадаад худалдаа, автомашин, явган замын хашлага хавтан үйлдвэрлэл" чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулах улсын бүртгэлийн гэрчилгээтэй бөгөөд "Программ хангамж, компьютерийн үйлчилгээ"-ний чиглэлийг гэрээний хугацаа дууссанаас хойш буюу 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр улсын бүртгэлийн гэрчилгээнд шинээр нэмжээ. Гэрээний хугацаа нь 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдөр байсан.

- Сүрьеэгийн цахим бүртгэлийн системийг шинэ системд оруулахад бэлтгэх, веб хуудастай холбох 10.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын удирдамжийг Эрүүл мэндийн дэд сайдаар, төсвийг ЭМЯ-ны ТНБД-аар 2020 оны 5 дугаар сард батлуулжээ. Ажил гүйцэтгэх гэрээг ЭМЯ-ны ТНБД Я.А[redacted] батлуулан, "Билэгт Жим" ХХК-тай 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан байна. Энэхүү компани нь "Хүнд машин механизмын тоног төхөөрөмжийн худалдаа" чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулах Улсын бүртгэлийн гэрчилгээтэй бөгөөд "Программ хангамж, компьютерийн үйлчилгээ"-ний чиглэлийг "Лүсүн Од" ХХК-ний нэг адил гэрээний хугацаа дууссанаас хойш буюу 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр улсын бүртгэлийн гэрчилгээнд шинээр нэмжээ. Гэрээний хугацаа нь 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдөр байсан.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг мөрдөлгүй, гэрээ байгуулалгүйгээр бараа шууд худалдан авч хууль зөрчсөн байна. Үүнд:

- Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн Хөтөлбөр зохицуулах нэгжийн хөрөнгөд бүртгэлтэй УНЧ 0536 улсын дугаартай Toyota Land cruiser 200 маркийн автомашины хөдөлгүүр солиулах ажлыг гүйцэтгүүлэхээр 17.0 сая төгрөгийг "Хангайтан зон" ХХК-ний дансанд 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр шилжүүлжээ. Үнийн саналыг "Хангайтан зон" ХХК-с 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн. Дээрх компаниас өөр байгууллагаас үнийн санал аваагүй бөгөөд Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг мөрдөөгүй, мөн гэрээ байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна. Хөтөлбөр зохицуулах нэгжээс ирүүлсэн мэдээллийн дагуу шалгахад УНЧ 0536 улсын дугаартай Toyota Land cruiser 200 маркийн автомашины хөдөлгүүрийг солиогүй буюу машины Техникийн тодорхойлолтод заасан хөдөлгүүрийн дугаар одоо ашиглаж байгаа хөдөлгүүрийн дугаартай тохирч байсан. Зураг 2. /Албан шаардлага хүргүүлэх/

Зураг 2. Сольсон гэх 0536 улсын дугаартай Toyota Land cruiser 200 маркийн автомашины хөдөлгүүрийн дугаар





41 MGL

1.ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Улсын дугаар: 8009УБС

Марк: Toyota Landcruiser

Ангилал, хөдөлгүүрийн багтаамж: B, 4000

Зориулалт: Суудал

Үйлдвэрлэсэн он: 2008

Хөдөлгүүрийн №: 5869717

Арал №: JTMCU09J804015088

Бүхээгийн №

Өнгө: Цагаан

Монгол Улсад орж ирсэн огноо: 2008/12/19

Гаргасан: 20 .. он ... сарын ... ны өдөр

АЯ № 0206361



3. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслөөс цалинждаг Хөтөлбөр зохицуулах нэгжийн зөвлөхтэй давхар ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, санхүүжилт олгосон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/245 дугаар тушаалаар АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхимийн эрхлэгч Р.О[redacted] НЭМҮТ-ийн захирал Д.Н[redacted] нарыг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн зөвлөхөөр томилсны дагуу Хөтөлбөр зохицуулах нэгжээс гэрээ байгуулж, сар бүр Р.О[redacted] 1000 ам.долларын, Д.Н[redacted] 500 ам долларын цалин олгож байсан.

  Төслийн хүрээнд "Сүрьеэ судлал, ХДХВ, ДОХ ба БЗДХ болон халдварын хяналт, сэргийлэлтийн төгсөлтийн өмнөх сургалтын гарын авлага" боловсруулах удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар, ажлын төсвийг ЭМЯ-ны ТНБД-аар 2020 оны 11 дүгээр сард батлуулсан байна. Удирдамжид зааснаар ажлыг гүйцэтгэх байгууллага нь АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхим бөгөөд тэнхимийн эрхлэгч нь Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн зөвлөхөөр ажиллаж, сар бүр цалин хөлс авч байсан Р.О[redacted] байсан. Р.О[redacted] нь 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хүсэлт гаргаж, Төрийн сангийн санхүүжилт 12 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болох тул гарын авлага боловсруулж, хэвлүүлэх ажлын санхүүжилт 39.283 сая төгрөгийг хамтран ажиллах байгууллага "Монголын ДОХ-той тэмцэх нийгэмлэг" ТББ руу шилжүүлье гэжээ. Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах ёстой байсан боловч зөвлөх Р.О[redacted]ийн хүсэлтийн дагуу 39.283 сая төгрөгийг "Монголын ДОХ-той тэмцэх нийгэмлэг" ТББ руу шууд шилжүүлсэн байна. "Монголын ДОХ-той тэмцэх нийгэмлэг" нь сургалтын гарын авлага боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхимийн 5 багштай нийт 24.3 сая төгрөгийн гэрээ хийсний дотор тэнхимийн эрхлэгч, төслийн зөвлөх Р.О[redacted] багтсан бөгөөд гарын авлага өнөөг хүртэл хэвлэгдээгүй байна.

**Хоёр. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,сүрьеэгийн төсөл, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан 2020-2021 онд Монгол Улсад олгосон буцалтгүй тусламж, Вируст гепатитаас сэргийлэх төслийн 2021 оны үйл ажиллагааны санхүүгийн хяналт, шалгалтыг хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:**

**1. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төсөл:**

1.1 Төсвийн тухай хуулийг зөрчиж, Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн сар тутмын хэрэглээний мөнгийг зориулалтын бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т зээл, тусламж, тэдгээрээр үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байхаар заасан. Хөтөлбөр зохицуулах нэгжийн зохицуулагчаар ажиллаж байсан Н.Ц[redacted] нь нэгжийн сар бүрийн хэрэглээний зардал болох 1.0 сая төгрөгийг бөөн дүнгээр шилжүүлэн авч, зориулалтын бусаар зарцуулснаар Төсвийн тухай хуулийн 6

дугаар зүйлийн 6.4.2-т "Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна. Н.Ц[redacted] нь Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн хэрэглээний зардалд ашиглах ёстой бэлэн мөнгөөр 868.0 мянган төгрөгийн үнэ бүхий Япон улсын Норитаке брэндийн шаазан эдлэлийг Поларис их дэлгүүрээс, 541.5 мянган төгрөгийн үнэртэнг Lion D'OR Mongolie дэлгүүрээс, 560.0 мянган төгрөгийн хүзүүний ороолтыг Шангрилла их дэлгүүр дэх "Ame" дэлгүүрээс, нийт 29 удаа 7,062.0 мянган төгрөгийн үнэ бүхий шоколад, чихэр, жимс, самар, хунчир, вино, жигнэмэг, чипс, жүүс, гэр ахуйн хэрэглээний бараа, цай, ус, рашаан ус, савласан бэлэг зэрэг хүнсний бүтээгдэхүүн, гэр ахуйн үйлчилгээг Номин, Е-март, Эфес хүнсний дэлгүүр болон үйлчилгээний байгууллагаас худалдан авч, нийт 9,031.5 мянган төгрөгийн төсвийн мөнгийг зориулалтын бусаар зарцуулжээ /Албан шаардлага хүргүүлэх/.

1.2 Салбар хүлээн авагч байгууллагууд нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн, нэг үйл ажиллагааг салангид эх үүсвэрээс санхүүжүүлсэн зөрчил гаргасан байна. Үүнд:

- Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн салбар хүлээн авагч "Эрүүл, сүрьеэгүй ирээдүйн төлөө" ТББ нь 2021 оны 3 дугаар сарын 08-ны өдөр "Монголын сайн сайхны төлөө нийгмийн ил тод байдлын нэгдсэн судалгаа" ТББ-тай цахим мэдээллийн системийг ашиглан, олон нийтэд мэдээлэл түгээх 6.25 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. "Монголын сайн сайхны төлөө нийгмийн ил тод байдлын нэгдсэн судалгаа" ТББ нийт 7 мэдээ, 4 ярилцлагыг олон нийтийн хэвлэл мэдээллийн 42 цахим хуудсанд 3 дугаар сарын 24-ний өдрөөс 6 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл байршуулан ажиллаж, гэрээг дүгнүүлсэн байна. "Эрүүл, сүрьеэгүй ирээдүйн төлөө" ТББ нь дээрх үйлчилгээтэй яг адил үйлчилгээг гүйцэтгүүлэхээр "Өлгий самурк консалтинг групп" ХХК-тай 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдөр 6 сарын гэрээ байгуулан, нэгдүгээр улиралд 2.47 сая төгрөг, 2 дугаар улиралд 17.51 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, нийт 5 мэдээг зөвхөн Arslan.mn цахим хуудсанд байршуулжээ. Байршуулсан цахим хуудас нь "Монголын сайн сайхны төлөө нийгмийн ил тод байдлын нэгдсэн судалгаа" ТББ байгууллагын мэдээ байршуулсан цахим хуудастай давхцаж байна. "Өлгий самурк консалтинг групп" ХХК нь Баян-Өлгий аймагт байрладаг фермерийн үйл ажиллагаа, бизнесийн зөвлөгөө, судалгаа, явуулын кафе, аялал, жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх Улсын бүртгэлийн гэрчилгээтэй ХХК байна.
- "Эрүүл, сүрьеэгүй ирээдүйн төлөө" ТББ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол (Босго үнэ тогтоох тухай энэхүү тогтоол нь 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан)-ыг зөрчин, "Глобальвишн" ХХК-тай 17.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, сүрьеэ өвчний талаарх видео контентыг зохиож, олон нийтэд түгээх хуудсанд байршуулах гэрээ хийсэн байна.

“Глобальвишн” нь программ хангамж, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах Улсын бүртгэлийн гэрчилгээтэй ХХК юм.

- “Эрүүл, сүрьеэгүй ирээдүйн төлөө” ТББ нь “Энх-Арслан” ХХК-тай 2021 оны 3 дугаар сарын 08-ны өдөр сүрьеэ өвчний талаар эрүүл мэндийн боловсрол олгох гарын авлага хэвлүүлэхээр 12.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан нь мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг зөрчсөн байна. Хөтөлбөр зохицуулах нэгжийн зохицуулагч Н.Ц[illegible]гийн буруутай үйл ажиллагаанаас хамаарч, 2021 оны төслийн санхүүжилт, салбар хүлээн авагч байгууллагууд руу 3 дугаар сард буюу бүтэн нэг улирал хоцорч шилжсэнээс “Эрүүл, сүрьеэгүй ирээдүйн төлөө” ТББ нь 1 дүгээр улиралд үйл ажиллагаа явуулахын тулд иргэн Ч.Э[illegible] (Энх-Арслан ХХК-ний гүйцэтгэх захирал)-аас 16.0 сая төгрөгийг 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр гэрээ байгуулан зээлжээ. Үүнээс 2 сарын дараа “Энх-Арслан” ХХК-тай шууд гэрээ байгуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хандив, санхүүгийн туслалцаа авахтай холбогдсон хязгаарлалтыг зөрчсөн байна. “Энх-Арслан” ХХК нь гадаад худалдаа эрхлэх, хүнсний дэлгүүр, цайны газар ажиллуулах, бизнесийн зөвлөгөө өгөх, веб сайт хийх, үндэсний хувцасны үйлдвэрлэл худалдаа эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байгууллага юм. Глобаль сангийн ДОХ, сүрьеэгийн төслөөс 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Ниэр Фийлд Коммуникейшн” ХХК-тай КОВИД-19 цар тахлын үед сүрьеэ өвчнөөс сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны материалын эх бэлтгэх, хэвлэх, видео шторк бэлтгэх, цахим мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх 48.41 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд “Ниэр Фийлд Коммуникейшн” ХХК-ний захирал нь мөн иргэн Ч.Э[illegible] байна. “Ниэр Фийлд Коммуникейшн” нь программ хангамжийн үйл ажиллагаа, гадаад худалдаа, худалдааны зуучлал, холбооны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ чиглэлээр үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болохыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн хуудаснаас харж болно.

1.3 ДОХ, Сүрьеэгийн төслийн Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж, ХӨСҮТ-тэй гэрээ байгуулж, ажил гүйцэтгэсэн Төрийн бус байгууллага нь Эрүүл мэндийн сайдын баталсан төсвийг дур мэдэн өөрчилж, төсөвт тусаагүй зардлыг бий болгон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчин, шууд худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанаас C19RM шинэ төслийн 2021 оны хоёрдугаар хагас жилд гүйцэтгэх үйл ажиллагааны нэгтгэсэн удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар батлуулжээ. Энэхүү удирдамжийн нэгдүгээр хавсралтаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалттай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч мэргэжилтнүүдийн тандалт судалгаа хийх чадавхыг сайжруулах сургалтын удирдамж болон зардлыг

батлуулсан байна. ДОХ, Сүрьеэгийн төслийн Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжиин зохицуулагч Н.Ц, ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт эрхэлсэн дэд захирал Ж.Б нар нь “Монголын тархвар судлаачдын нийгэмлэг”-тэй сургалт зохион байгуулах 207.33 сая төгрөгийн гэрээ хийжээ. “Монголын тархвар судлаачдын нийгэмлэг”-ийн тэргүүн Ч.М нь Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамж дахь зардлын төсвийг дур мэдэн өөрчилж, сургалт хийх байрны түрээсийн мөнгө болох 43.2 сая төгрөгийн  38.5 сая төгрөгөөр холбогдох байгууллагаас зөвшөөрөл авалгүй ном хэвлүүлсэн байна. Ном хэвлүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг зөрчин, цахим хуудсанд тендерийн урилгыг зарлалгүй, худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулахгүйгээр “Наран зон принт” ХХК-тай шууд гэрээ  байгуулсан байна.

2. **Азийн хөгжлийн банк, Глобаль сангийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжсэн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх замаар вируст гепатит, сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааг сайжруулах төсөл:**

2.1 Азийн хөгжлийн банк, Глобаль сангийн хамтарсан санхүүжилтээр  хэрэгжсэн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх замаар вирусг гепатит, сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааг сайжруулах төслийн санхүүгийн хяналт, шалгалтыг хийхэд анхан шатны баримтыг хангалтгүй бүрдүүлсэн зөрчил илэрсэн. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд 2019 онд албан томилолтоор ажилласан тайлан дутуу, албан томилолтын хуудасгүй, томилолтын тооцоо хийгээгүй байсан.

3. **Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд коронавирусг халдвар (КОВИД-19)-ын арга хэмжээний механизмаар дамжуулан Монгол Улсад /буцалтгүй тусламж/ хэрэгжүүлж буй нэмэлт (C19RM) төсөл:**

3.1 Салбар хүлээн авагч байгууллагууд нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахаас зайлсхийж, төсөвт өртгийг хувааж, худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- “Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг” Төрийн бус байгууллага нь өсвөр үеийнхэнд чиглэсэн сүрьеэ өвчний талаар үнэн зөв мэдээлэл олгох интерактив сургалтын материал боловсруулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх ажилд зориулан нийт 80.99 сая төгрөгийн санхүүжилтийг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,сүрьеэгийн төслөөс хүлээн авсан байна. Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийг тогтоож, харьцуулалтын үнээр худалдан авч болох үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 70.0 сая төгрөг байхаар, шууд

худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 20.0 сая төгрөг байхаар, цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаарыг 20.0 сая төгрөг байхаар тус тус заасан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасан байна. "Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг" ТББ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг илтэд зөрчин, интерактив сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг нийт 3 багцад хуваан, шууд худалдан авч, 2 багцад "Хүрд пресс" ХХК-тай 1 багцад "Хөх Монгол дизайн" ХХК-тай тус тус гэрээ байгуулсан байна. "Хүрд пресс" ХХК нь хэвлэх үйлдвэр, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, реклам чимэглэл, гэрэлтүүлэг, гадаад худалдаа, мебель модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэх Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байна. "Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг" ТББ-аас тайлбар өгөхдөө Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилтан Т.Х[redacted]гийн тулгаж өгсөн хэд хэдэн компанийг сонгож, гэрээ хийсэн гэсэн байна.

- "Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг" Төрийн бус байгууллага нь өсвөр үеийнхэнд чиглэсэн сүрьеэгийн чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагууд харилцан мэдээллээ солилцох платформ боловсруулах ажлын санхүүжилтэд нийт 87.65 сая төгрөгийн санхүүжилтийг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,сүрьеэгийн төслөөс хүлээн авсан байна. Энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэхдээ мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг зөрчин, нийт 5 багцад хуваaж, шууд худалдан авчээ. Гэрээг "Гэрэл софт", "Гялзаа", "Кемм технoложи", "Супер ассист системс", "Ану хас эрдэнэ" ХХК-тай байгуулжээ. "Гэрэлсофт" ХХК нь 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдөр байгуулагдсан, "КЕММ технoложи" ХХК нь 2021 оны 9 дүгээр сард байгуулагдсан, "Супер ассист системс" ХХК нь 2021 оны 9 дүгээр сард программ хангамжийн үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлдээ нэмсэн, "Гялзаа" ХХК нь 2021 оны 7 дугаар сард программ хангамжийн үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлдээ нэмсэн, "Ану хас эрдэнэ" ХХК нь 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр байгуулагдаж, 2021 оны 9 дүгээр сард программ хангамжийн үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлдээ нэмсэн байна. "Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг" тайлбар өгөхдөө мөн Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилтан Т.Х[redacted]гийн тулгаж өгсөн хэд хэдэн компанийг сонгож, гэрээ хийсэн гэжээ.

3.2 Салбар хүлээн авагч байгууллагууд нь санхүүгийн анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн, мөн гэрээ байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- "Монголын эрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо" нь Сүрьеэгийн диспансеруудтай харилцах, үйл ажиллагаанд нь хяналт тавих хөтөлбөр боловсруулах нийт 18.02 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авчээ. Хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд мэдээлэл солилцох вэб сайтын хөгжүүлэлт хийлгэхээр "Пенсек" ХХК-д 11.06 сая төгрөгийг гэрээ байгуулалгүйгээр шилжүүлсэн байна.
- "Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө" ТББ нь "Нью оптик" ХХК-иас 10.0 сая төгрөгний шатахууныг гэрээ байгуулалгүй худалдан авч, зарцуулалтын тайланг анхан шатны баримтад хавсарсаргаагүй байна.

**4.ДҮГНЭЛТ**

4.1 Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2020 оны үйл ажиллагааны хэсэгчилсэн санхүүгийн хяналт шалгалтаар 155.7 сая төгрөгийн, 2021 оны үйл ажиллагааны санхүүгийн хяналт шалгалтаар 265.62 сая төгрөг, нийт 421.32 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

4.2 Илэрсэн зөрчлүүдийн дийлэнх буюу 86.7 хувь нь худалдан авах ажиллагаатай холбоотой, 13.3 хувь нь албан тушаалтан албан тушаалын эрхээ урвуулан ашиглахтай холбоотой байна.

4.3 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т зээл, тусламж, тэдгээрээр үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байхаар заасан бөгөөд илэрсэн зөрчлөөс харахад төсвийн хөрөнгийг хууль, журмын дагуу үр ашигтай захиран зарцуулах асуудал хангалтгүй байна.

4.4 Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн Хөтөлбөр зохицуулах нэгжийн зохицуулагчаар ажиллаж байсан Н.Ц нь албан тушаалын эрхээ урвуулан ашиглаж, төсвийн хөрөнгөөс 9.0 сая төгрөгийг зориулалтын бусаар зарцуулаад зогсохгүй өөрийн хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсан нь удаа дараа байгуулсан хууль бус гэрээ, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа ажлуудаас илэрхий байна.

4.5 Хөтөлбөр зохицуулах нэгж, Салбар хүлээн авагч байгууллагууд нь Төрийн болон орон нутгийг өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахаас зайлсхийж, төсөвт өртгийг хуваах, худалдан авалт хийсэн зөрчлийг удаа дараа гаргасан байна.

4.6 Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн ажилтан Т.Х нь Салбар хүлээн авагч байгууллагуудад Төрийн болон орон нутгийг өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг илт зөрчсөн үйлдэл хийхийг санал болгож, хэрэгжүүлүүлсэн, гүйцэтгэгч сонгож, гэрээ байгуулахад нөлөөлсөн зохисгүй үйлдэл гаргасан байна.

4.7 Бараа, үйлчилгээ худалдан авахдаа үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудтай гэрээ байгуулан, гүйцэтгүүлээд зогсохгүй санхүүгийн анхан шатны баримтыг засварласан байна.

4.8 Албан томилолтоор орон нутагт ажиллахдаа томилолтын хуудасгүй явах, томилолтын тайлан тооцоог хийхгүй, санхүүгийн анхан шатны баримтыг зохих ёсоор нь бүрдүүлээгүй байна.

## 5. ЗӨВЛӨМЖ

1. Төсвийн тухай хуулийн 17.1-д "олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна" гэж заасан тул мөн хуулийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.
2. Цаашид Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах, төслийн хүрээнд байгуулсан аливаа ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг тайланд үндэслэн дүгнэж хэвших.
3. Худалдан авах ажиллагаатай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэлээс сэргийлэх.
4. Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулахгүй байх.
5. Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж, нэг төсөвт өртгийг хэд хэдэн хэсэгт хувааж худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх.
6. Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авалт хийж болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлах
7. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсныг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх.
8. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчсөн салбар хүлээн авагч байгууллагуудын гэрээг цуцлах.
9. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжээс цалин хөлс авдаг мэргэжилтнүүдтэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ хийхгүй байх.
10. Салбар хүлээн авагч байгууллагуудын санхүүгийн анхан шатны бүрдлийн бүрэн байдлыг хангаж ажиллах.

Танилцсан: С.Төгсдэлгэр, ХШҮДАГ-ын дарга

Гүйцэтгэсэн: Х.Өлзий-Орших, ХШҮДАГ-ын шинжээч

Г.Туул, ХШҮДАГ-ын шинжээч

Д.Тунгалаг, ХШҮДАГ-ын шинжээч